



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 104

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 3, 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Тариалан эрхлэлтийг дэмжих сан, түүний харьяа сангуудын /хуучнаар/ үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны үнээ нөхсөн нийт 124,385,545.00 (нэг зуун хорин дөрвөн сая гурван зуун наян таван мянга таван зуун дөчин тав) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан 7 (долоон) ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн гүйцэтгэх захирал Э.Батбаяр түүний харьяа сангуудын дарга /хуучнаар/ нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2020 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ

0000205

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 2-дугаар сарын 21-ны өдрийн
104 дугаар тогтоолын хавсралт

ТАРИАЛАН ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САН ТҮҮНИЙ ХАРЬАА САНГУУДЫН /ХУУЧНААР/
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

д/д	Автомашинны марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ /төгрөг/	Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Үлдэх өртөг /төгрөг/	Сэргээн босголтын зардал /төгрөг/	Худалдах доод үнэ /төгрөг/
1.Төв сан								
1	Хьюндай өргөгч машин HD-160, улсын дугаар 7230УНН, арал-KMFDA19VPC006963	2000/2010	375953	72,150,000.00	72,150,000.00	-	-	7,000,000.00
2	Ниссан экстрал, улсын дугаар 519 0 СЭУ, арал-5N1ED28YC520369	2000/2015	190000	18,600,000.00	18,600,000.00	-	-	1,000,000.00
3	Зил-130, улсын дугаар 6648 УББ арал-3395878	1994/2012	279069	509,945.00	509,945.00	-	-	2,000,000.00
	Дүн			91,259,945.00	91,259,945.00			10,000,000.00
2.Хөтөл салбар								
1	ММС кантер ачааны, улсын дугаар 7255УБН, арал 500356	1994/2005	307218	10,123,200.00	10,123,200.00	-	-	1,000,000.00
	Дүн			10,123,200.00	10,123,200.00			1,000,000.00
3.Хархорин салбар								
1	Зил-130 ачааны, улсын дугаар 1493ӨВА	1993/1994	250000	5,065,200.00	5,065,200.00	-	-	500,000.00
2	Тоёота пандкрузер-80, улсын дугаар 5354ӨВР, арал-FZJ80-0144340	1996/2012	299999	10,492,200.00	10,492,200.00	-	-	1,000,000.00
	Дүн			15,557,400.00	15,557,400.00			1,500,000.00

д/д	Автомашинны марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ /төгрөг/	Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Үлдэх өртөг /төгрөг/	Сэргээн босголтын зардал /төгрөг/	Худалдах доод үнэ /төгрөг/
4.Сэлэнгэ салбар								
1	Ниссан атлас-150, улсын дугаар 5316ДАА, арал-Р4F23-012014	1994/2002	193487	7,445,000.00	7,445,000.00	-	-	700,000.00
	Дүн			7,445,000.00	7,445,000.00			700,000.00
	Нийт дүн			124,385,545.00	124,385,545.00			13,200,000.00
				(нэг зуун хорин дөрвөн сая гурван зуун наян таван мянга таван зуун дөчин тав)				(арван гурван сая хоёр зуу)